# СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 1.1. | **Зорилт 1**. Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | | | | | | |
| 1.1.1 | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, АХ 2050-1.1.4, МУХТЖҮЧ-1.1.4, ЗГҮАХХАХТ-2.6.3.6, МУХТҮЧ-1.13.218 | Засгийн газрын хурал-даанаар хэлэлцүүлсэн эсэх | Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа хийгдсэн. | 100% | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын орчуулгыг албан ёсоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэн хянуулж байна. Конвенцын орчуулга нь Хууль зүй, дотоод хэргийн яам болон анх орчуулсан эхтэй ойлголтын зөрүү гараад байгаа тул нэгтгэх уулзалт хийх шаардлагатай болсоноос ажил бага зэрэг хойшилогдоод байна. Конвенцын танилцуулга, үзэл баримтлал, хууль боловсруулахтай холбоотой урьдчилсан бэлтгэл, холбогдох материалыг бэлтгэсэн. | IV улирал | 50% |
| 1.1.2 | Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх багц хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулах АХ 2050-1.1.4 | Хуулийн үзэл баримтлал батлагдсан эсэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан | 100% | Соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, засварлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх", Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Түүхэн барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах тухай", Төрөөс соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих эрх зүйн үндсийг | III-IV улирал | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоож, соёлын биет бус өвийг хамгаалах оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг дэмжих тухай", Соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварт нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлж, үнэлгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хяналт тавих, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлж "Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн төслийг тус тус боловсруулсан. | | |
| 1.1.3 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах **МУЗГТХ 24.1** | Бодлогын баримт бичгүүд батлагдсан эсэх | - | 100% | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Үр дүнд суурилсан төсөвлөлтийн зөвлөхүүдтэй хамтран Залуучуудын хөгжлийн бодлого, стратегийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэхүү баримт бичгийн тайланг сайдад танилцуулсан. | IV улирал | 100% |
| 1.1.4 | Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх багц хуулийн төслийг боловсруулах, **АХ 2050-1.1.4,** | Хуулийн үзэл баримтлал батлагдсан эсэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан | 100% | Соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, засварлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх", Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Түүхэн барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах тухай", Төрөөс соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, соёлын биет бус өвийг хамгаалах оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой | III-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдсон харилцааг зохицуулахаар “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг дэмжих тухай”, Соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварт нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлж, үнэлгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хяналт тавих, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлж “Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн төслийг тус тус боловсруулсан. | | |
| 1.1.5 | Соёлын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, бусад арга хэмжээ **СХТ - 21.1** | Арга хэмжээний тоо, дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | - | 100% | -Эдийн засгийн хөгжлийн яаманд ССАЖЗ-ын Сайдын 2024 оны 1/500 албан бичгээр хөтөлбөрийн санал хүргэгдэж Монгол Улсын Их хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан.<br><br>-Эдийн засгийн хөгжлийн яаманд ССАЖЗСайдын 2024 оны 1/11 тоот албан бичгээр хөтөлбөрийн санал хүргэгдэж Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан.<br><br>-Эдийн засгийн хөгжлийн яаманд ССАЖЗСайдын 2024 оны 11 дүгээр сарын 1/955 тоот албан бичгээр салбарын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хүргүүлсэн. | III-IV улирал | 100% |
| 1.1.6 | ЮНЕСКО-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай | Дэмжлэг үзүүлсэн зорилтын тоо | - | 100% | Соёлын сайдын 2024 оны А/121 дүгээр тушаал, ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2005 конвенцын хэрэгжилт хангах **СТХ - 21.1.1** | | | | ЮНЕСКО-ийн 2005 оны конвенцын дэргэдэх “Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан”-ийн талаарх мэдлэг ойлголт олгох, олон нийтийн хүртээл болгох үйл ажиллагааг ЮНЕСКО-ийн Зүүн Ази дахь төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисстой хамтран зохион байгуулж соёл, урлагийн байгууллага, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нийт 30 мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хамтын удирдлагын байгууллагын төлөөлөл нийт 78 хүнийг хамруулсан. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Конвенцын Иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх тухай 11 дүгээр зүйл, Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санг олон нийтийн хүртээл болгох тухай 18 дугаар зүйлийн хэрэгжилтийг тус тус хангаж ажилласан. https://moc.gov.mn/news/surgalt | | |
| 1.1.7 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах **МУЗГТХ-30.1, БХУЗТХ-12.1.2, МУЗГ-2023 оны 481 тогтоол** | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1)Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/139 тоот албан бичгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гаргасан Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Соёлын салбарт хамаарал бүхий арга хэмжээг шуурхай зохион байгуулж, төлөвлөгөөний биелэлтийг | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ханан ажиллав. Тус төлөвлөгөөнд туссан дараах 2 арга хэмжээний хүрээнд:<br>**1.6-д** Соёлын үйлдвэрлэлийн бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томоохон төслүүдийн саналыг салбарын бүх талын оролцоог хангаж хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан үр дүнг нэгтгэн боловсруулж, ЭЗХЯ-д хүргүүлэх. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>а/ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоол 2024 оны 6 сарын 6-ны өдөр батлагдаж соёлын салбараас нийт 14 зорилтуудыг тусгуулаа.<br>**2.10-д** МУ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын өвийн дурсгалт газар, СББӨ-ийн байршил, 21 аймгийн бүх музей, театр, соёлын төвийн байршил, хүчин чадлын мэдээллийг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-д хүргүүлэх. Үүнд:<br>а/ Нийслэл, бүс орон нутгуудын түүх, соёлын онцлогт тулгуурласан соёлын үйлдвэрлэлийн бүсчлэл, кластерыг тодорхойлох, тэдгээрт байрлах цогцолбор, дэд бүтцийн байршил, орон зай, соёлын байгууллагуудын байршлын мэдээлэл, тэдгээрийн насжилт, хүчин чадлын жагсаалт, Соёлын биет бус өвийн 2022 оны тоон дүн мэдээ, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын www.rich.mongoluv.mn программд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2022 оны тоон дүн мэдээ, Соёлын бүсчлэлийг орон зайн чадавхад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үндэслэн тодорхойлох судалгааны үр дүн зэрэг албан бичигт дурдсан дата мэдээллийг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газарт цахимаар хүргүүлсэн.<br><br>2/ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дараах байдлаар туссан:<br>1.2.2.4.Хөшгийн хөндийд шинээр бий болох сургалт, эрдэм шинжилгээний цогцолборыг түшиглэн “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулна.<br>1.3.1.3.Орхон голын сав, Хангай нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.2.1.Алтайн нуруу, байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдалт, тусгай сонирхол, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Их нуурууд, Отгонтэнгэр хайрханд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.3.1.Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.6.1.Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтай овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна.<br>3.3.6.7.Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг “Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар” агуулгаар хөгжүүлж “Буддын шашны соёлын өвийн цогцолбор” болгоно.<br>3.3.6.8.Богд хааны ордон музейн орчмыг VIII Богд Жавзандамба хутагтын амьдарч ирсэн түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж, хөгжүүлнэ.<br>3.3.6.9.Монгол кино үйлдвэр орчмыг монгол киноны түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж хөгжүүлнэ гэж тус тус туссан. | | |
| 1.1.8 | “Спорт ХАБ”-ыг 2-3 байгууллагад туршин, үр дүнг тооцох, санхүүжүүлэх аргачлал болон орон нутгийн иргэдийн бие бялдрын хөгжлийн тайлан гаргах аргачлал боловсруулах **АХ 2050-3.5-2** | Санхүүжүүлэх, хөгжлийн тайлан гаргах аргачлалуудын төслийг боловсруулсан эсэх | - | 100% | Спортын ХАБ-ыг байгуулах ажлын хүрээнд хүн амын насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөрийн төсөл, үр дүнг тооцох, санхүүжүүлэх аргачлал болон орон нутгийн иргэдийн бие бялдрын хөгжлийн тайлан гаргах аргачлалыг боловсруулсан. Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын жишиг төвийг байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 4 төвийн тоног төхөөрөмжийг хүлээн авч Нийслэлд Баянгол, Налайх дүүргүүдэд тоног төхөөрөмжийг байршуулсан, цаашид 2 аймагт тоног төхөөрөмжийг байршуулж, цахим системийн үйл ажиллагааг нэвтрүүлэн ажиллаж байна. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЖ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭН ГАДААД СУРТАЛЧИЛГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 2.1.1 | Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлалыг боловсруулах<br><br>**МУТЖҮЧ – 8.2.2** | Үзэл баримтлал боловсруулагдсан эсэх | - | 100% | Их Эзэн Чингис хааны түүхийг илэрхийлсэн аялал жуулчлалын цогцолборуудын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаатай холбоотой тус цогцолборуудын үзэл баримтлалд түшиглэн Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлалыг боловсруулах шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ асуудлаар Чингис хааны өв соёлын хүрээлэнтэй уулзалт хийж төлөвлөгөө гарган ажиллаж байна. | III-IV улирал | 50% |
| 2.1.2 | Буйр нуурын усан боомтыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулах<br><br>**ЗГҮАХ 1.3.6.1** | Төлөвлөгөө батлагдсан эсэх | - | 100% | Буйр нуурын усан боомтыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний боловсруулах зорилгоор аялал жуулчлалын нөөцийг тодорхойлох суурь судалгаа болон холбогдох материалд дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлж Үндэсний Статистикийн хороотой уулзалт зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд:<br>- “Дорнод аймгийн Халх гол сумын Буйр нуурын загас агнуурын менежментийн төлөвлөгөө-2023”<br>- Дорнод нутгийн аялал жуулчлалыг 2021-2027 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр<br>- Буйр нуур, Халх гол сумын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө-2025<br>- Монгол Улсын зүүн бүсийн хөгжлийн үзэл баримтлалын төсөл | III-IV улирал | 70% |
| 2.1.3 | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг зүүн бүсийн “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгох | Менежментийн төлөвлөгөө батлагдсан эсэх | - | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын бүс” болгон албан ёсоор зарласан. Түүхэн аялал жуулчлалын бүсийг | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах<br><br>**МУТЖҮЧ – 8.2.2** | | | | зарласантай холбоотой тус бүсийг хөгжүүлэх төлөвлөгөөг "Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор баталсан. | | |
| 2.1.4 | Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах<br><br>**ЗГҮАХ 1.3.6.1** | Менежментийн төлөвлөгөө батлагдсан эсэх | - | 100% | Аялал жуулчлалын тухай хууль хууль шинэчлэгдэн батлагдаж хуулийн 18 дугаар зүйлд Хил орчмын аялал жуулчлалын асуудлыг зохицуулахаар тусгагдсан. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хил орчмын аялал жуулчлалаар гадаадын иргэн Монгол Улс руу нэвтрэх асуудлыг хөрш улстай харилцан тохиролцож, Монгол Улсын олон улсын гэрээгээр шийдвэрлэнэ." гэж заасны дагуу "Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд:<br>- Нэг жилийн хүчинтэй хугацаатай, олон удаагийн "орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх" эзэмшигч бүлэг жуулчдын ахлагч, эсхүл хөтөч орчуулагч нь визгүйгээр Монгол улсад нэвтрэх үнэмлэх, гурван сарын хүчинтэй хугацаатай нэг удаагийн "хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий орох, гарах БНХАУ-ын үнэмлэх"-ийг 2 улс дипломат шугамаар харилцан тохиролцсон.<br>- Бүлэг жуулчдын нэрсийн жагсаалтын загваруудыг хамтран батлах ёстойг хятадын талаас санал ирж, Монголын талын холбогдох байгууллагууд ГХЯ, ГИХГ, ХХЕГ, ССАЖЗЯ саналаа нэгтгэн хүргүүлэхээр ажиллаж байна.<br>- Хил орчмын аялал жуулчлалын нутаг | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэвсгэрт гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах заалтын хүрээнд хил орчмын аймгуудтай хамтран маршрутыг боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлээд байна. Энэ асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр хил орчмын аялал жуулчлалыг эхлүүлэхэд бэлэн болж байна. | | |
| **ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **3.1** | **Соёлын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | |
| 3.1.1 | Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах журмын төслийг боловсруулж батлуулах **СТХ-8.3** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүн хэн байж болох талаар санал авсан. Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Чингис хаан болон анхдугаар Богд Занабазар гэсэн түүхэн 2 хүний санал өгсөн. Чингис хаан өв соёлын хүрээлэнгээс Чингис хааны дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах, хамгаалах чиглэлээр санал ирүүлсэн. Журмын төслийг 6 бүлэг, 16 зүйл бүхий байхаар боловсруулсан. | III-IV улирал | 90% |
| 3.1.2 | Соёлын төв, ордны үлгэрчилсэн дүрмийн төслийг боловсруулж батлуулах **СТХ-25.3** | Дүрмийн төсөл батлагдсан эсэх | - | 100% | Соёлын тухай хуулийн 25.3, 37.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны жишиг дүрэм”, “Сум, дүүргийн Соёлын төв, Соёлын ордны үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-н төслийг боловсруулж, ТНБД-ын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 3/512, 3/513 тоот албан бичгээр ЗГХА Соёл урлагийн газар болон аймаг, нийслэлийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас саналыг авч тусган, | III-IV улирал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүрмийн төслийг холбогдох албан тушаалтнаар хянуулахад бэлэн болсон. | | |
| 3.1.3 | Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төсөл боловсруулж батлуулах **СТХ-26.4** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Соёлын тухай хуулийн 26.4-т “Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төслийг боловсруулж 10.14-ны өдрийн ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаар салбарын ТББ-ын судалгааг чиг үүргийн шинжилгээтэй уялдуулан нарийвчлан хийх санал гарсны дагуу журмын төсөлд дахин боловсруулалт хийж, яамны бүтцийн нэгжүүдээс санал авах ажил зохион байгуулж эхэлсэн. | III-IV улирал | 90% |
| 3.1.4 | Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаг-лалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулж, батлуулах **СТХ-18.6** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын чуулганаар шинэчлэн батлагдсан Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална” гэж заасан. Соёлын яамнаас хуулийн хэрэгжилтийг хангаж, Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг эрх зүйн хүрээнд зохицуулах зорилгоор журмын төслийг боловсрууллаа. Соёлын тухай хуульд зааснаар Удирдах зөвлөл нь удирдлага, урын сангийн | III-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулахаар журамд зохицуулалтыг тусгасан болно.<br><br>Соёлын яамны эрхлэх асуудлын хүрээнд 25 төрийн өмчийн соёлын байгууллага, соёлын асуудал эрхэлсэн аймаг, нийслэлийн 22 газар, орон нутгийн өмчийн 432 соёлын байгууллага Соёлын тухай хуульд заасан соёл, урлагийн үйл ажиллагаа явуулж байна.<br><br>“Төрийн болон Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын төсөл нь 7 зүйл, 31 хэсэг, 19 заалттай, нийтлэг үндэслэл, Зөвлөлийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааны хэлбэр, Зөвлөлийн гишүүний бүрэн эрх, байгууллагын эрх, үүрэг болон түүнд холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Засгийн газрын ээлжит хурлаар батлуулахаар тогтоолын төслийг боловсруулж, холбогдох яамдаас саналыг авахаар албан бичгийг боловсруулсан. | | |
| 3.1.5 | Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, урал-даан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах **СТХ-32.9** | Журам батлагдсан эсэх | - | 100% | Соёлын тухай хуулийн 32.9-т “Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолоор баталсан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох тухай журам, уралдаан наадмын жагсаалтыг өөрчлөх төсөл | III-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулж 10.14-ны өдрийн ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаар салбарын уралдаан наадмын жагсаалтын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан гаргах санал гарсны дагуу дахин боловсруулалт хийж эхэлсэн. | | |
| **3.2 Музейн тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 3.2.1 | Орон нутгийн музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуур, үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, батлуулах **МТХ- 7.3, 7.4** | Аргачлалыг батлуулсан эсэх | - | 100% | Музейн тухай хуулийн 7.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дөрвөн жил тутам хараат бус хуулийн этгээдээр үнэлгээ хийлгэнэ”, 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээ хийх аргачлал, үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуурыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу “Музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ хийх аргачлал”, “Музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуур” төсөл боловсруулсан. | III-IV улирал | 70% |
| 3.2.2 | Монгол Улсын харьяат 16 хүртэлх насны хүүхдийн хувийн музейгээр үйлчлүүлсэн холбогдох зардлыг нөхөн олгох олгох журмын төслийг боловсруулж батлуулах **МТХ- 9.4** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Музейн тухай хуулийн 9.4-д заасны дагуу “Монгол Улсын харьяат 16 хүртэлх насны хүүхдийн хувийн музейгээр үйлчлүүлсэн холбогдох зардлыг хувийн музейд нөхөн олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулсан. Төсөлд 16 хүртэлх насны хүүхдийн хувийн музейгээр үйлчлүүлсэн зардлыг хэлэлцүүлэг судалгаа хийсний үр дүнд тухайн музейн урсгал зардлаас хасаж тооцохоор оруулсан ч Сангийн яамнаас хүүхдийн тарифыг тогтоож | III-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зардлыг тооцох саналаар буцаасан. /Гэвч музейн тухай хуульд Монгол Улсын харьяат 16 хүртэлх насны хүүхэд музейгээр үнэ төлбөргүй үйлчлүүлэхээр заасан/ Иймд уг асуудлаар 12 дугаар сарын 25-ны өдөр оролцогч талуудыг байлцуулан хэлэлцүүлэг хийхээр төлөвлөөд байна. | | |
| **3.3 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 3.3.1 | Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг боловсруулж, хүргүүлэх **СӨХТХ- 9.1** | Журмын төсөл боловсруул сан эсэх | - | 100% | ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүн хэн байж болох талаар санал авсан. Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Чингис хаан болон анхдугаар Богд Занабазар гэсэн түүхэн 2 хүний санал өгсөн. Чингис хаан өв соёлын хүрээлэнгээс Чингис хааны дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах, хамгаалах чиглэлээр санал ирүүлсэн. Журмын төслийг 6 бүлэг, 16 зүйл бүхий байхаар боловсруулсан. Зорилт 2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд: Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7-д түүхийн дурсгалт зүйл, үнэт эдлэл, эрдэнэс, ховор эд зүйлийн үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална гэж заасан хууль хоорондын нэр томьёоны ойлголт зөрж байгаа тул Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтийн төлөөлөлтэй 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр уулзалт хийж | III-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ярилцан хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулахаар ярилцсан. Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж Соёлын биет өвийн үнэлгээний журам, аргачлалыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батлахаар заасан. Үнэлгээний журмын төслийг боловсруулж Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтийн төлөөлөлд саналыг илгээсэн. | | |
| 3.3.2 | Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг боловсруулж, батлуулах **СӨХТХ-35.1** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1-д заасны дагуу Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Чингис хаан Үндэсний музей дээр зохион байгуулсан “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх” сургалтын үеэр музейн сан хөмрөгчдөд танилцуулан санал авч тусган, дахин зарим боловсруулалтыг хийж байна. | III-IV улирал | 100% |
| 3.3.3 | Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, батлуулах **СӨХТХ 45.1** | Шалгуур үзүүлэлтийн төсөл батлагдсан эсэх | - | 100% | Барилга, хот байгуулалтын сайд, Соёлын сайдын хамтарсан 2024 оны 30/А43 дугаар тушаалаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг 2024 оны 9 дүгээр сард хуралдуулж, хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг эцэслэн боловсруулсан | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бөгөөд соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулахаар бэлтгэсэн. | | |
| 3.3.4 | Түүхэн дурсгалт, барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг төслийг боловсруулж батлуулах **СӨХТХ-47.2** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Журмын төслийг боловсруулж, нөлөөллийн шинжилгээг хийсэн бөгөөд Соёлын яамны дэргэдэх Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг журмын төсөлд тусгасан. Соёлын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны А/413/247 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийг хуралдуулж, журмын төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулахаар бэлтгэсэн. | III-IV улирал | 70% |
| **3.4 Кино урлагийг дэмжих тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 3.4.1 | Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг боловсруулж, батлуулах **КУДТХ- 14.3** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмын төслийг боловсруулж холбогдох газраас санал авсан бөгөөд “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эцэслэн боловсруулсан. | III-IV улирал | 90% |
| **3.5 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1 | Монгол Улсын иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох журмыг төслийг боловсруулж, батлуулах<br><br>**СБҮДТХ 8.4** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | 1/ Сайдын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/10 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>2/Ажлын хэсгийн гишүүд 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр сайдад ажлын явцыг танилцуулах уулзалтыг зохион байгуулж a) тухайн журмын төслийн боловсруулалтын явц, b) журмын хэрэгжилтийн урьдчилсан зураглал, c) системийн бүтцийн зураглал, d) Францын эрхийн бичгийн талаарх судалгааны талаар танилцууллаа.<br><br>3/Сайдаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тооцоо судалгаа, цаашид эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө болон журмын төслийг эцэслэн боловсруулж 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ТНБД-ын 3/774 тоот албан бичгээр “Соёл, спортын бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, түгээх, түүнийг худалдан авах эрхийн бичиг олгох журам”-ын төсөлд ирүүлсэн өмнөх саналыг тусган, Засгийн газрын шийдвэрийн төсөл болон холбогдох бусад баримт бичгийн хамт санал авахаар яамдад хүргүүлсэн.<br><br>4/ ССАЖЗ-ын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1072 тоот албан бичгээр Монгол Улсын сайд, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Соёл, спортын бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, түгээх, түүнийг худалдан авах эрхийн бичиг олгох журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга, нөхцөл байдлын шинжилгээ, | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яамдаас ирүүлсэн саналын хамт хавсралтаар хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг уламжилсан болно. | | |
| **3.6 Аялал жуулчлалын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 3.6.1 | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг боловсруулж, батлуулах **АЖТХ 6.5** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлагын стандартыг олон улсын стандарттай харьцуулан шинэчлэхээр зочид буудлуудын төлөөлөл бүхий 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж стандартын шинэчилсэн төслийг боловсруулаад байна.<br><br>- MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандартын төслийг 247 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулаад байна.<br><br>- MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлагын стандартын төслийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, өрөө үйлчилгээ, угтах үйлчилгээ, хүний нөөцийн гэсэн чиглэлүүдээр баг бий болгон 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна дэн буудал, гэр буудал, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын төлөөллийг хамруулж ажилласан.<br><br>- MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандартыг 15 зүйл, 126 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулж, 4 удаа хэлэлцүүлсэн. Дээрх стандартуудыг 2024 оны 12 дугаар сарын 09- | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдөр сүүлийн хэлэлцүүлгийг хийн стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна. | | |
| 3.6.2 | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал зэрэглэл тогтоох журмыг батлуулах **АЖТХ 16.1.6** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох журмын төслийг боловсруулж үе шаттай хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын гишүүдээс санал авах арга хэмжээг зохион байгуулж байна. | III-IV улирал | 100% |
| **3.7 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 3.7.1 | Сайн дурын ажлыг бүртгэж баталгаажуулах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах **ЗХДТХ 15.2** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Залуучуудын сайн дурын үйл ажиллагааны нийтлэг шаардлага, стандарт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/69 дугаартай Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан, 1 удаагийн танхим уулзалт зохион байгуулж, Монголын сайн дурын үйл ажиллагааны стандартын төсөл боловсрууллаа.<br><br>-Дээрх ажлын хэсгийн хүрээнд Дэлхийн сайн дурынхны өдрийг тохиолдуулан "Тогтвортой хөгжилд сайн дурынхны оролцоо" чуулганыг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/75 дугаартай тушаалаар зохион байгуулж, 500 залуучууд оролцож, Чуулганаар "Сайн дурын ажлыг бүртгэж баталгаажуулах журам" болон стандартын хүрээнд санал авч зөвлөмж боловсрууллаа. | III-IV улирал | 100% |
| **3.8 Гэр бүлийн тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.8.1 | Угийн бичиг хөтлөх журмыг боловсруулж, батлуулах **ГБТХ-10.4** | Журмын төсөл батлагдсан эсэх | - | 100% | Соёлын сайдын 2024 оны А/148 дугаар тушаалаар угийн бичиг хөтлөх гарын авлага бэлтгэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хурлаар 2007 онд Засгийн газрын 257 дугаар тогтоолоор баталсан "Угийн бичиг хөтлөх журам"-ын төслийг шинэчлэх санал гарч, шинэчилсэн төслийг 2 удаа хэлэлцүүлсэн. | III-IV улирал | 90% |
| 3.8.2 | "Соёлын бүтээлч сар 2024" аяныг зохион байгуулах **СТХ -34.3, ЗГ-ын 2022 оны 314 дүгээр тогтоол** | Аян зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан эсэх | - | 100% | - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/77 тоот тушаалаар "Соёлын бүтээлч сар" аяныг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилт хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулав.<br>- Ажлын хэсгийн ахлагч,дэд ахлагч нар 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр сайдад "Соёлын бүтээлч сар 2024" аяны агуулга, зохион байгуулалтын хувилбар болон аяны агуулга, дүр төрх, нэгдсэн төлөвлөгөө, зохион байгуулалтад шаардагдах зардлын нарийвчилсан задаргааг тус тус танилцуулж, чиглэл авч ажиллав. Мөн "Соёлын бүтээлч сар-2024" аяныг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь, зохион байгуулах удирдамжийн төслийг танилцуулж, батлуулав.<br>- Аяны хүрээнд соёлын үйлдвэрлэл, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, түүнийг олон нийтэд танилцуулах зорилгоор соёлын олон талт арга хэмжээ, үзэсгэлэн, экспо, сургалт семинар, урлагийн тоглолт, хэлэлцүүлэг зэрэг нийт **2715** (*Тоглолт, арга хэмжээ 959, Боловсролын хөтөлбөр 578, Хэлэлцүүлэг, сургалт, хурал 558,* | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | *Нөлөөллийн ажил 620)* арга хэмжээг 21 аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй соёл, урлагийн байгууллагууд, хувийн хэвшил, хувь уран бүтээлчдийн оролцоотойгоор улс орон даяар зохион байгуулсан. Тухайлбал, Соёлын төв, ордон 702,926, Улс аймгийн Музей 136,393, Номын сангууд 126,310, Мэргэжлийн урлагийн байгууллага, Театр, чуулгууд 102,129, Хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хувь уран бүтээлчид **2,211,** нийт **1,069,969** иргэн, үүнээс 46% буюу **496,374** нь хүүхэд, 0,7% буюу **7661** хөгжлийн бэрхшээлтэй иргэн соёл, урлагийн үйлчилгээнд биечлэн хамрагдсан бол давхардсан тоогоор **7,326,118** иргэн цахимаар хандсан.Энэ удаагийн аяныг “Соёлын өв”, “Урлаг, уран бүтээл”, “Соён гэгээрэл”, “Спорт” гэсэн төрөлд ангилан орчин цагийн Монгол Улсын түүхэнд онцлох гавьяа байгуулсан эрхэм хүмүүсээс дөрвөн хүмүүнийг алдаршуулан, тэдний эрхэмлэн дээдэлж ирсэн үнэт зүйлс, ур чадвар, гавьяат үйлсийг хойч үе, хүүхэд, залууст сурган таниулах, түгээхэд чиглэсэн болно.<br>- Тухайлбал, Соёлын өвийн төрөлд Улсын их хатан Дондогдулам, Урлаг, уран бүтээлийн төрөлд Монгол Улсын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Эрэгзэнгийн Чойдог, Соён гэгээрэл төрөлд Монголын орчин цагийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, их зохиолч Сономбалжирын Буяннэмэх, Спортын төрөлд Монгол Улсын Гавьяат тамирчин, Хөдөлмөрийн баатар, Дархан аварга Жигжидийн Мөнхбат зэрэг түүхэн хүмүүсийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | алдаршуулав.Аяны хүрээнд уламжлал болсон нэгдсэн форумыг 11 дүгээр сарын 28-ны өдөр "Хөрөнгө оруулалт-Хамтын ажиллагаа" соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум Улаанбаатар зочид буудлын их танхимд зохион байгуулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан "Гар зураг"-ийн уралдаан болон "Эсээ бичлэг"-ийн уралдааны шагнал гардуулах ёслол, "Соёл, спорт, аялал жуулчлалын салбар"-ын нэгдсэн бодлогын танилцуулга, "Соёл, спортын эрхийн бичиг" танилцуулга илтгэл, Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын орчин, боломж" илтгэл, Соёлын өвийн эрх зүйн шинэтгэл: "НӨӨЦ-БАЯЛАГ-ҮНЭ ЦЭНЭ" илтгэл зэрэг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>- Аяны зохион байгуулалтад Сайдын А/121,А/126, А/128, А/130, А/134 дугаар тушаал, ТНБД-ын А/49 тоот зардлын тушаалууд тус тус батлагдсан болно. | | |
| ҮНЭЛГЭЭ | | | | | | | 85.3% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

СТРАТЕГИ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

А.ДАВААЖАРГАЛ /........................../

.......... .......... ..........
*( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.ЭНХТУЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. СОЁЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЧИГЛЭЛИЙГ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНД ТУЛГУУРЛАН ТОДОРХОЙЛЖ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан байна. | Эдийн засгийн хөгжлийн яаманд СCАЖЗ-ын Сайдын 2024 оны 1/500 албан бичгээр хөтөлбөрийн санал хүргэгдэж Монгол Улсын Их хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан. | IV улирал | 100% |
| 2 | **Арга хэмжээ 1.2:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан байна. | Эдийн засгийн хөгжлийн яаманд СCАЖЗСайдын 2024 оны 1/11 тоот албан бичгээр хөтөлбөрийн санал хүргэгдэж Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан. | IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.3:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Төлөвлөгөөний төсөл ЭЗХЯ-д хүргэгдсэн байна. | Эдийн засгийн хөгжлийн яаманд ССАЖЗСайдын 2024 оны 11 дүгээр сарын 1/955 тоот албан бичгээр салбарын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хүргүүлсэн. | IV улирал | 100% |
| | **Арга хэмжээ 1.4:** Салбарын нэгдсэн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Баримт бичиг боловсруулагдсан байна. | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Үр дүнд суурилсан төсөвлөлтийн зөвлөхүүдтэй хамтран салбарын бодлого, стратегийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэхүү баримт бичгийн тайланг сайдад танилцуулсан. | IV улирал | 100% |
| | **Арга хэмжээ 1.5:** Салбарын нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Баримт бичиг боловсруулагдсан байна. | Эдийн засгийн хөгжлийн яаманд ССАЖЗСайдын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 1/1317 албан бичгээр саналыг хүргүүлсэн. | IV улирал | 100% |
| | **Арга хэмжээ 1.6:** Соёлын салбарын бодлого, төлөвлөлтийн 5 боть ном боловсруулж, хэвлүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Ном хэвлэгдсэн байна. | Соёлын салбарын бодлого, төлөвлөлтийн 5 боть ном боловсруулах, ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэхүү ажлын хэсгээс салбарын удирдлага зохион ілт /Соёлын салбарын судалгаа/ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ан бүтээлийг хөгжүүлэх бодлого эвийг хөгжүүлэх үндсэн чиглэл ээрэл 2030 бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг номын төсөл боловсруулагдсан. эх бэлтгэл болон хяналт явагдаж тус эвлэгдэж байна. | IV улирал | 100% |
| **ЗОРИЛТ 2. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИЖ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1:** “Соёлын бүтээлч сар” -ын нэгдсэн форумын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын “Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт”-ийн илтгэлийг боловсруулах | Зохион байгуулагдсан эсэх | - | Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт”-ийн илтгэлийг боловсруулсан байна. | “Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт”-ийн илтгэлийг боловсруулж “Соёлын бүтээлч сар” -ын нэгдсэн форумын үеэр илтгэл тавьсан. | IV улирал | 100% |
| **ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАХ** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1:** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, | Баримт бичгийн тоо | - | Хуульд заасан хугацаанд хариу хүргүүлсэн байна Тайлан үнэн зөв, цаг хугацаанд нь тайлагнаж байх | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, цаг хугацаанд нь тайлагнасан. Мөн нэгжийн хүрээнд хийгдсэн Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Таван жилийн үндсэн хөгжил, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон сар бүрийн тайланг | IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан тушаалтанд хүргүүлэх. | | | | боловсруулан хуулийн хугацаандаа багтаан moc.igovernment.mn-д тайлагнасан. | | |
| 2 | **Арга хэмжээ 3.2:** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Баримт бичгийн тоо | - | Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байдал | Албан хэрэг хөтлөлт, баримтжуулалтын үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу үйлдэж, бүрдүүлэлт хийн, архивын нэгж үүсгэн, хүлээлгэн өгч архивд шилжүүлсэн баримтын бүртгэл хийлээ. Үүнд: Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн түвшнийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн стратеги , төлөвлөгөө боловсруулах тендерийн материалыг хүргүүлэв. | III улирал, IV улирал | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан форумын | Илтгэлийг боловсруулсан эсэх | - | Илтгэлийг боловсруулсан байна | Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан форумын | 2024.11.29 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | илтгэлийг боловсруулсан. | | | | арга хэмжээний “Хөрөнгө оруулалт ба хамтын ажиллагаа илтгэлийг боловсруулж ТНБД илтгэл тавьсан. | | |
| 2. | “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах тухай хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдэх ажлын танилцуулгыг боловсруулсан. | Санал боловсруулсан эсэх | - | Саналыг боловсруул сан байна | Монгол- Орос- Хятад “Цайны их зам” төслийн танилцуулгыг боловсруулж Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 2024.11.08 | 100% |
| 3. | ССАЖСайдын А/08 тушаалаар батлагдсан Салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тогтолцооны зураглал гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг орж ажилласан. | Ажлын хэсгээс санал боловсруулсан эсэх | - | Саналыг боловсруул сан байна | Салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тогтолцооны зураглал гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж сайдад 2 удаа танилцуулсан. | 2024.11.11<br>2024.11.21 | 100% |
| 4. | Газрын moc.igovernment.mn системээр авдаг 5 бодлогын баримт бичгийн тайланг гаргаж ажилласан. | Тайлан гаргадаг эсэх | - | 5 тайланг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | 1. Алсын хараа 2050<br>2. Хууль тогтоомжийн хэрэгжилт<br>3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө<br>4. 5 жилийн Үндсэн чиглэл | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Гадаад улсад өөрийн чиг үүргийн дагуу сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан эсэх | - | Танхимаар | Малайз Улсын Кучинг хотноо зохион байгуулагдах НҮБ-ын Аялал жуулчлалын Ази, Номхон далайн бүсийн аялал жуулчлалын бодлого, стратегийн 18 дахь удаагийн сургалтад 2024.10.27-11.01 хооронд хамрагдаж “Тансаг аялал жуулчлал”-ын бодлогын сертификат гардан авсан. | 11 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Ахлах шинжээч Ч.Энхтуяа ............ (албан тушаал) | ............ (Нэр, гарын үсэг) | 2024.12.11 (Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.ЭНХТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Нэгжийн нэр: Стратеги, бодлого төлөвлөлтийн газар

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | 60 | | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | 60 | | | |
| 3 | **Арга хэмжээ 1.3:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх. | 60 | | | |
| 4 | **Арга хэмжээ 1.4:** Салбарын нэгдсэн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах | 60 | | | |
| 5 | **Арга хэмжээ 1.5:** Салбарын нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэх | 60 | | | |
| 6 | **Арга хэмжээ 1.6:** Соёлын салбарын бодлого, төлөвлөлтийн 5 боть ном боловсруулж, хэвлүүлэх | 60 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1:** "Соёлын бүтээлч сар" -ын нэгдсэн форумын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын "Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт"-ийн илтгэлийг боловсруулах | 60 | | | |
| **ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАХ** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | 60 | | | |
| 2. | Арга хэмжээ 3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | 60 | | | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1 | Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан форумын илтгэлийг боловсруулсан. | 60 | | | |
| 2 | "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах тухай хөтөлбөр"-ийн хүрээнд хийгдэх ажлын танилцуулгыг боловсруулсан. | 60 | | | |
| 3 | ССАЖСайдын А/08 тушаалаар батлагдсан Салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тогтолцооны зураглал гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг орж ажилласан. | 60 | | | |
| 4 | Газрын moc.igovernment.mn системээр авдаг 5 бодлогын баримт бичгийн тайланг гаргаж ажилласан. | 60 | | | |
| **Дундаж оноо:** | | | | | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Гадаад улсад өөрийн чиг үүргийн дагуу сургалтад хамрагдсан байна. | 100 % | 15 | 15 |
| | **Дундаж оноо** | | | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | | |
| 4. | Хариуцлагатай байдал | | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| | **Дундаж оноо** | | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| | **Дундаж оноо** | |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| | **Нийт оноо** | 90 / 91 |

***Үнэлгээ өгсөн:*** **Нэгжийн дарга**
Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга ........................ (А.Даваажаргал)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

........................ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Ахлах шинжээч
Ч.Энхтуяа ........................ (Ч.Энхтуяа)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

........................ *(огноо)*

***Үнэлгээг хянасан:*** ***Үнэлгээний багийг төлөөлж, ахлагч***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ........................ (Д.Түмэндэмбэрэл)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*
ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн ........................ (Х.Даваасүрэн)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ (А.Даваажаргал)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

ATA12931 6594204 9024070548

........................ *(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ГАНХУЯГ ОВОГТОЙ АРИУНЗАЯАГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. СОЁЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЧИГЛЭЛИЙГ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНД ТУЛГУУРЛАН ТОДОРХОЙЛЖ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах. | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | - | Үзэл баримтлалд тусгагдсан салбарт хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br><br>1)Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/139 тоот албан бичгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан гаргасан Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Соёлын салбарт хамаарал бүхий арга хэмжээг шуурхай зохион байгуулж, | IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний биелэлтийг ханан ажиллав. Тус төлөвлөгөөнд туссан дараах 2 арга хэмжээний хүрээнд:<br>**1.6-д** Соёлын үйлдвэрлэлийн бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томоохон төслүүдийн саналыг салбарын бүх талын оролцоог ханган хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан үр дүнг нэгтгэн боловсруулж, ЭЗХЯ-д хүргүүлэх. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>а/ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоол 2024 оны 6 сарын 6-ны өдөр батлагдаж соёлын салбараас нийт 14 зорилтуудыг тусгуулллаа.<br>**2.10-д** МУ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын өвийн дурсгалт газар, СББӨ-ийн байршил, 21 аймгийн бүх музей, театр, соёлын төвийн байршил, хүчин чадлын мэдээллийг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-д хүргүүлэх. Үүнд:<br>а/ Нийслэл, бүс орон нутгуудын түүх, соёлын онцлогт тулгуурласан соёлын үйлдвэрлэлийн бүсчлэл, кластерыг тодорхойлох, тэдгээрт байрлах цогцолбор, дэд бүтцийн байршил, орон зай, соёлын байгууллагуудын байршлын мэдээлэл, тэдгээрийн насжилт, хүчин чадлын жагсаалт, Соёлын биет бус өвийн 2022 оны тоон дүн мэдээ, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын www.rich.mongoluv.mn программд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн, Түүх, | | |

20

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2022 оны тоон дүн мэдээ, Соёлын бүсчлэлийг орон зайн чадавхад үндэслэн тодорхойлох судалгааны үр дүн зэрэг албан бичигт дурдсан дата мэдээллийг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газарт цахимаар хүргүүлсэн.<br><br>2/ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дараах байдлаар туссан:<br>1.2.2.4.Хөшигийн хөндийд шинээр бий болох сургалт, эрдэм шинжилгээний цогцолборыг түшиглэн “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулна.<br>1.3.1.3.Орхон голын сав, Хангай нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.2.1.Алтайн нуруу, байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдалт, тусгай сонирхол, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Их нуурууд, Отгонтэнгэр хайрханд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.3.1.Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.<br>1.3.6.1.Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтай овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна.<br>3.3.6.7.Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг "Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлж "Буддын шашны соёлын өвийн цогцолбор" болгоно.<br>3.3.6.8.Богд хааны ордон музейн орчмыг VIII Богд Жавзандамба хутагтын амьдарч ирсэн түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж, хөгжүүлнэ.<br>3.3.6.9.Монгол кино үйлдвэр орчмыг монгол киноны түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж хөгжүүлнэ гэж тус тус туссан. | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2:** Монгол Улсын иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох журмыг төслийг боловсруулж, батлуулах. | Журмын төсөл боловсруулагдсан эсэх | - | Журмын төслийг боловсруулж, холбогдох баримт бичгийн хамт Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | 1/ Сайдын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/10 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>2/Ажлын хэсгийн гишүүд 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр сайдад ажлын явцыг танилцуулах уулзалтыг зохион байгуулж a) тухайн журмын төслийн боловсруулалтын явц, b) журмын хэрэгжилтийн урьдчилсан зураглал, c) системийн бүтцийн зураглал, d) | IV улирал | 100% |

22

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Францын эрхийн бичгийн талаарх судалгааны талаар танилцуууллаа.<br><br>3/Сайдаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тооцоо судалгаа, цаашид эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө болон журмын төслийг эцэслэн боловсруулж 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ТНБД-ын 3/774 тоот албан бичгээр “Соёл, спортын бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, түгээх, түүнийг худалдан авах эрхийн бичиг олгох журам”-ын төсөлд ирүүлсэн өмнөх саналыг тусган, Засгийн газрын шийдвэрийн төсөл болон холбогдох бусад баримт бичгийн хамт санал авахаар яамдад хүргүүлсэн.<br><br>4/ ССАЖЗ-ын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1072 тоот албан бичгээр Монгол Улсын сайд, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Соёл, спортын бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, түгээх, түүнийг худалдан авах эрхийн бичиг олгох журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга, нөхцөл байдлын шинжилгээ, яамдаас ирүүлсэн саналын хамт хавсралтаар хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг уламжилсан болно. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 2. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИЖ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1:** “Соёлын бүтээлч сар” аяныг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах. | Зохион байгуулагдсан эсэх | “Соёлын бүтээлч сар -2023” аянд 3461 арга хэмжээ зохион байгуулагдсан. | - | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/77 тоот тушаалаар “Соёлын бүтээлч сар” аяныг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилт хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулав.<br>Ажлын хэсгийн ахлагч,дэд ахлагч нар 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр сайдад “Соёлын бүтээлч сар 2024” аяны агуулга, зохион байгуулалтын хувилбар болон аяны агуулга, дүр төрх, нэгдсэн төлөвлөгөө, зохион байгуулалтад шаардагдах зардлын нарийвчилсан задаргааг тус тус танилцуулж, чиглэл авч ажиллав. Мөн “Соёлын бүтээлч сар-2024” аяныг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь, зохион байгуулах удирдамжийн төслийг танилцуулж, батлуулав.<br>Аяны хүрээнд соёлын үйлдвэрлэл, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, түүнийг олон нийтэд танилцуулах зорилгоор соёлын олон талт арга хэмжээ, үзэсгэлэн, экспо, сургалт семинар, урлагийн тоглолт, хэлэлцүүлэг зэрэг нийт **2715** (*Тоглолт, арга хэмжээ 959, Боловсролын хөтөлбөр 578, Хэлэлцүүлэг, сургалт, хурал 558, Нөлөөллийн ажил 620)* арга хэмжээг 21 аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй соёл, урлагийн байгууллагууд, | IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувийн хэвшил, хувь уран бүтээлчдийн оролцоотойгоор улс орон даяар зохион байгуулсан. Тухайлбал, Соёлын төв, ордон 702,926, Улс аймгийн Музей 136,393, Номын сангууд 126,310, Мэргэжлийн урлагийн байгууллага, Театр, чуулгууд 102,129, Хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хувь уран бүтээлчид **2,211,** нийт **1,069,969** иргэн, үүнээс 46% буюу **496,374** нь хүүхэд, 0,7% буюу **7661** хөгжлийн бэрхшээлтэй иргэн соёл, урлагийн үйлчилгээнд биечлэн хамрагдсан бол давхардсан тоогоор **7,326,118** иргэн цахимаар хандсан.<br>Энэ удаагийн аяныг “Соёлын өв”, “Урлаг, уран бүтээл”, “Соён гэгээрэл”, “Спорт” гэсэн төрөлд ангилан орчин цагийн Монгол Улсын түүхэнд онцлох гавьяа байгуулсан эрхэм хүмүүсээс дөрвөн хүмүүнийг алдаршуулан, тэдний эрхэмлэн дээдэлж ирсэн үнэт зүйлс, ур чадвар, гавьяат үйлсийг хойч үе, хүүхэд, залууст сурган таниулах, түгээхэд чиглэсэн болно. Тухайлбал, Соёлын өвийн төрөлд Улсын их хатан Дондогдулам, Урлаг, уран бүтээлийн төрөлд Монгол Улсын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Эрэгзэнгийн Чойдог, Соён гэгээрэл төрөлд Монголын орчин цагийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, их зохиолч Сономбалжирын Буяннэмэх, Спортын төрөлд Монгол Улсын Гавьяат тамирчин, Хөдөлмөрийн баатар, Дархан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аварга Жигжидийн Мөнхбат зэрэг түүхэн хүмүүсийг алдаршуулав.<br>Аяны хүрээнд уламжлал болсон нэгдсэн форумыг 11 дүгээр сарын 28-ны өдөр “Хөрөнгө оруулалт-Хамтын ажиллагаа” соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум Улаанбаатар зочид буудлын их танхимд зохион байгуулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдсан “Гар зураг”-ийн уралдаан болон “Эсээ бичлэг”-ийн уралдааны шагнал гардуулах ёслол, “Соёл, спорт, аялал жуулчлалын салбар”-ын нэгдсэн бодлогын танилцуулга, “Соёл, спортын эрхийн бичиг” танилцуулга илтгэл, Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын орчин, боломж” илтгэл, Соёлын өвийн эрх зүйн шинэтгэл: “НӨӨЦ-БАЯЛАГ-ҮНЭ ЦЭНЭ” илтгэл зэрэг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>Аяны зохион байгуулалтад Сайдын А/121,А/126, А/128, А/130, А/134 дугаар тушаал, ТНБД-ын А/49 тоот зардлын тушаалууд тус тус батлагдсан болно. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.2:** Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, аймаг, нийслэлийн | Гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн тоо | Гэрээний хавсралтын тоо, Төлөвлөгөөний тоо, | Гэрээ -22<br>Төлөвлөгөө-22<br>Тайлан-22 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ХЭГ/2742 албан бичгийн дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2024 онд хамтран ажиллах | III улирал, IV улирал | 70% |

26

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Засаг дарга нарын хооронд байгуулах хамтран ажиллах гэрээний хавсралтыг боловсруулах, жилийн эцсийн гэрээний гүйцэтгэлийн тайланг дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах. | | Тайлангийн тоо. | | гэрээний төслийн 5 дугаар хавсралтыг боловсруулан танилцуулсан.<br>Энэхүү хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/176 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.<br>Ажлын хэсэг 2 удаа нэгдсэн хуралдаан хийж гэрээний хавсралтын төслийн боловсруулалтыг ажлын хэсэгт танилцуулан чиглэл авч саналыг төсөлд тусган сайжруулалтыг хийсэн.<br>Тайлангийн хугацаанд багтаан жилийн эцсийн гэрээний гүйцэтгэлийн тайланг дүгнэхээр хүлээгдэж байна. | | |
| **ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАХ** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1:** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан | Баримт бичгийн тоо | - | Хуульд заасан хугацаанд хариу хүргүүлсэн байна Тайлан үнэн зөв, цаг хугацаанд нь тайлагнаж байх | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, цаг хугацаанд нь тайлагнасан. Мөн нэгжийн хүрээнд хийгдсэн Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Таван жилийн үндсэн хөгжил, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон сар бүрийн тайланг боловсруулан хуулийн хугацаандаа багтаан moc.igovernment.mn-д тайлагнасан. | III улирал, IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тушаалтанд хүргүүлэх. | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 3.2:** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Баримт бичгийн тоо | - | Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байдал | Албан хэрэг хөтлөлт, баримтжуулалтын үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу үйлдэж, бүрдүүлэлт хийн, архивын нэгж үүсгэн, хүлээлгэн өгч архивд шилжүүлсэн баримтын бүртгэл хийлээ. Үүнд:<br>Соёлын бүтээлч сар 2024 аяны нэгдсэн тайлангийн 2 боть материал. | III улирал, IV улирал | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** | Төлөвлөгөө батлагдсан эсэх | Боловсруулагдсан | Төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. | “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл”, хэрэгжүүлэх | IV улирал | 70% |

28

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл", хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн үр дүнгийн үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, оролцогч талуудыг тодорхойлсон нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулах, олон нийтэд сурталчлах ном товхимол болгох. | | төлөвлөгөөний төсөл | | арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж соёлын сайдаар батлуулах, олон нийтэд сурталчлах ном товхимол болгох ажлын хүрээнд салбарын эрдэмтэн, судлаач багш нартай хамтран арга хэмжээ тус бүрд нөхцөл байдлын шинжилгээ хийж, хүрэх үр дүн, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүнгийн үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, оролцогч талуудыг тодорхойлж, төслийг боловсруулсан. | | |
| 2. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.**<br><br>Төрийн болон олон улсын байгууллагын зардлаар соёлын салбарт хийгдсэн судалгааг "Төрийн судалгааны нэгдсэн системд бүртгэх" -тэй | Судалгааны системд бүртгэсэн судалгааны тоо | 2023 онд системд 23 судалгааг бүртгэсэн. | Судалгааны системд судалгааг нэмэлтээр бүртгэсэн байна | Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01- ний өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлд судалгааны нэгдсэн систем бүрдүүлж төрийн байгууллагуудын захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн системд бүртгэх, хянах, засварлах ажлыг засгийн газрын гишүүд холбогдох төрийн байгууллагуудад даалгасантай холбогдуулан өнгөрсөн онд соёлын салбарт 2019-2022 он хүртэлх хугацаанд хийгдсэн судалгааны ажлын | IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотой ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах. | | | | мэдээллийг нэгтгэн цахим системд бүртгэсэн. Уг ажлыг эрчимжүүлэн үргэлжлэл болгож хамаарах салбарын болон харьяа байгууллагын түвшинд олон улсын болон төрийн зардлаар хийгдсэн судалгааны ажлыг нэгтгэхээр нэгж хоорондын санал солилцох хуудас боловсруулан хүргүүлж, ирүүлсэн судалгааны ажлыг нэгдсэн системд бүртгэх ажлыг гүйцэтгэв.<br>Соёлын яамны газар нэгжүүдээс Соёлын сайдын 2024 оны А/91, 2023 оны А/394 тушаалын дагуу 87,470,000 төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн 3 судалгааг системд бүртгэлжүүлэв. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сургалтад хамрагдах | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сургалтад хамрагдах | - | Цахимаар болон танхимаар сургалтад хамрагдсан байна. | Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад 3 удаагийн сургалт, - Төрийн албаны зөвлөлөөс "Албан тушаалын хүчин зүйлийн үнэлгээ" судалгаа сургалт, - Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, | 07-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд багтан шинэчлэн мэдүүлэх болсонтой холбогдуулсан сургалтад цахимаар тус тус хамрагдсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Бусад төрийн байгууллага болон яамнаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Бусад төрийн байгууллага болон яамнаас зохион байгуулах сургалтад хамрагдах | - | Цахимаар болон танхимаар сургалтад хамрагдсан байна. | “Эйбл” систем ашиглалтад орохтой холбоотой зохион байгуулсан сургалт, "Төрийн болон албаны нууцын тухай хууль анхаарах асуудал"-аар Тагнуулын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад тус тус хамрагдав. | 07-12 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Соёлын бүтээлч үйлдвэрлэл,
инновацын бодлого, төлөвлөлт,
тайлагналт, судалгаа хариуцсан шинжээч — Г.Ариунзаяа /............................ — ............ ................ ............

(албан тушаал ) — (Нэр, гарын үсэг) — (Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ГАНХУЯГ ОВОГТОЙ АРИУНЗАЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Нэгжийн нэр: Стратеги, бодлого төлөвлөлтийн газар

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах. | 60 | | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Монгол Улсын иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох журмын төслийг холбогдох баримт бичгийн хамт боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх. | 60 | | | |
| **Зорилт 2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. “Соёлын бүтээлч сар” аяныг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах. | 60 | | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулах хамтран ажиллах гэрээ, гэрээний гүйцэтгэлийн тайлан дүгнэх, хэрэгжилтийг хангах. | 60 | | | |
| **ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАХ** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, | 60 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | | | | |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | 60 | | | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.**<br>“Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл”, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд арга хэмжээ тус бүрийн үр дүнгийн үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, оролцогч талуудыг тодорхойлсон нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж соёлын сайдаар батлуулах, олон нийтэд сурталчлах ном товхимол болгох. | 50 | | | |
| 2. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.**<br>Төрийн болон олон улсын байгууллагын зардлаар соёлын салбарт хийгдсэн судалгааг “Төрийн судалгааны нэгдсэн системд бүртгэх” -тэй холбоотой ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах. | 60 | | | |
| **Дундаж оноо:** | | | | 61 | 61 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад хамрагдсан байна. | | 15 | 14 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Төрийн байгууллага болон яамнаас зохион байгуулах сургалтад хамрагдана. | | 15 | 14 |
| **Дундаж оноо** | | | | 14 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан |
|---|---|---|---|

| | | | баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 7 | 7 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 61 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо** | | 90/90 |

***Үнэлгээ өгсөн:*** **Нэгжийн дарга**
Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга ........................ (А.Даваажаргал)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.....2024.12.10..... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын бодлого, төлөвлөлт, тайлагналт, судалгаа хариуцсан шинжээч ........................./ (Г.Ариунзаяа)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.12...... (огноо)

***Үнэлгээг хянасан:*** ***Үнэлгээний багийг төлөөлж, ахлагч***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ...................................... (Д.Түмэндэмбэрэл)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ТЗҮГ-ын ахлах мэргэжилтэн ...................................... (Х.Даваадорж)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ...................................... (А.Даваажаргал)
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*

АТА12931 6594204 9024070548

## САЛБАРЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Д.МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин /жилээр/ | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| НЭГ. "ОРОН НУТАГ ДАХЬ СОЁЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХЭТИЙН ЧИГЛЭЛИЙГ СУДАЛГААНД ТУЛГУУРЛАН ТОДОРХОЙЛЖ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | |
| 1.1 | Ерөнхий сайдын 02 дугаар албан даалгаварын хүрээнд салбарын хүний нөөц, цахим, ногоон хөгжлийн стратеги, төлөвлөгөөний төсөл боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулах | Хэлэлцүүлэг зохион байгуулах, санал боловсруулах | Саналыг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна. | Ерөнхий сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаварын хүрээнд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хүний нөөц, цахим, ногоон хөгжлийн чиглэлээр стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулж, хэлэлцүүлэгийг цахимаар зохион байгууллаа.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.2 | Яамны хөдөлмөрийн дотоод журам боловсруулж батлуулах | Төсөл боловсруулж, хэлэлцүүлэн, батлуулсан эсэх | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан байна. | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/60 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн батлуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.3 | 2025 оны эвент, арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт боловсруулах | Боловсруулж, батлуулсан эсэх | Нэгдсэн төлөвлөлтийг санал авч, боловсруулсан байна | 2025 онд улсын хэмжээнд зохион байгуулагдах эвент, сургалт, томилолт зэрэг арга хэмжээ нэгдсэн төлөвлөлт боловсруулж ажиллалаа.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.4 | Яамны бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулах | Боловсруулж, батлуулсан эсэх | Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/01 дүгээр "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах" ажлын хэсгийг байгуулсан.<br>Энэ хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/05 дугаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | батлуулсан байна. | "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ажлын байрны нэр, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалыг баталж, төрийн өндөр 2, төрийн захиргааны 119, улс төрийн 4, төрийн үйлчилгээний 5, нийт 130 албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоосон.<br>Үүнээс төрийн захиргааны 118 албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Зөвшөөрөл олгох тухай" 373, 374, 375, "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 376 дугаар тогтоолоор тус тус албажсан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар "Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт батлах тухай" тушаалаар батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангалаа.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.5 | Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын процессын дахин инженерчлэлийн төлөвлөгөө боловсруулж, санал хүргүүлэх | Санал боловсруулж хүргүүлсэн эсэх | Санал боловсруулж ТБҮХ-нд хүргүүлсэн байна. | Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын процессын дахин инженерчлэлийн төлөвлөгөө боловсруулж, санал хүргүүллээ.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.6 | Олимпыг наадамд эрх авч оролцсон, амжилт гаргасан тамирчин дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан эсэх | Хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | “Парис 2024” зуны XXXIII олимп, паралимпын XVII наадамд алт, мөнгө, хүрэл медаль авсан тамирчид, эрхээ авч оролцсон тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн бүрэлдэхүүн болон шагналт байранд шалгарсан. Таеквондогийн эмэгтэйчүүдийн төрөлд У.Сүрэнжав алтан медаль хүртсэн бол Ц.Баттулга, Э.Содномпилжээ, Г.Болор-Эрдэнэ нар тус тус мөнгөн медаль хүртэж, нийт 4 медальтайгаар 57-р байрт жагссан амжилт үзүүлснийг тэмдэглэж, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. **Хэрэгжилт 100 хувь** |
| 1.7 | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан эсэх | Хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны А/... дугаар тушаалаар байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, 2024 оны 08 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд ажиллалаа.<br>Уг арга хэмжээний үеийн хүндэтгэлийн үйл ажиллагаанд 3 өдрийн турш нийт 700 гаруй зочдыг хүлээн авч, яамнаас 33 албан хаагч, 12 уран бүтээлчид нэгдэн ажилласан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 2.1 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бүтэц, зохион байгуулалтын зураглал, төлөвлөлт, холбогдох баримт бичгийг боловсруулан батлуулах | Бүтэц, орон тоог батлуулсан эсэх | Бүтэц, орон тоог батлуулсан байна. | Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолын дагуу яамны чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтад үнэлгээ хийж, бүтэц, орон тоог оновчтой тогтоох чиглэлээр "Дунд түвшний чиг үүргийн үүргийн шинжилгээ" хийж ажилласан.<br>Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 18 дугаар тогтоолоор "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг батлуулллаа.<br>Үүний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/05 дугаар "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ажлын байрны нэр, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалаар бүтэц, орон тоог баталж, төрийн өндөр 2, төрийн захиргааны 119, улс төрийн 4, төрийн үйлчилгээний 5, нийт 130 албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоосон.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

87

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2 | Хүний нөөцийн аудитын судалгаа, тайлан гаргаж хүргүүлэх | Салбарын 480 гаруй байгууллагын албан хаагчдын судалгаа гаргаж, ҮАГ-т хүргүүлсэн эсэх | Судалгаа, тайланг гаргаж, хүргүүлсэн байна. | Үндэсний Аудитын газраас улсын хэмжээнд хийж буй "Хүний нөөцийн аудит"-ын ажлын хүрээнд соёл урлаг, спорт, аялал жуулчлал, залуучуудын чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа 4 салбарын 484 байгууллагын 7552 албан хаагчийн "Төрийн байгууллагын гүйцэтгэлийн судалгаа"-г авч, нэгтгэн хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3 | Сайдын бодлогын зөвлөл байгуулах төслийг боловсруулж танилцуулах | Зөвлөлийн саналыг боловсруулсан эсэх | Бодлогын зөвлөлийг байгуулах саналыг танилцуусан байна. | Бодлогын зөвлөлд нэр дэвшүүлэх салбар салбарын 400 гаруй эрдэмтэн, судлаач, ажиллагчдын мэдээллийг цуглуулж, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, судалгааг эцэслэв.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

**ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ**

| | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1.1.1 | Яамны засвар, тохижилтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх | ТНБД-ын дарга А.Даваажаргал<br>ТЗУГ-ын дарга Ч.Энх-Амгалан | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/80, А/81 дүгээр тушаалаар яамны угтах хэсэг, хүндэтгэлийн гэрийн засвар, тохижилт хийх зардлыг шийдвэрлэн 2024 оны 12 дугаар сарын 05-30-ны өдрүүдэд хийж, гүйцэтгэлээ.<br>Уг засварын хүрээнд яамны лобби, бестифулийн 75,8 мкв талбайн шаланд плита, 70 мкв хананд гоёлын панел хана хийж, хүндэтгэлийн гэрт, засвар, тохижилтын ажил гүйцэтгэлээ.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.2 | Яамны хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | ТНБД-ын дарга А.Даваажаргал<br>ТЗУГ-ын дарга Ч.Энх-Амгалан | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/18 дугаар "Албан хаагчдынг чөлөөлж, томилох тухай" тушаалаар Соёлын яамны албан хаагчдыг чөлөөлж, Соёл, спорт, аялал |

| | | | |
|---|---|---|---|
| | | | жуулчлал, залуучуудын яамны чиг үүргийн хүрээнд томилгоо хийсэн. Энэ хүрээнд мэргэжлийн индекс зөрүүтэй, сонсох ажиллагаанаас өөрчлөлт орсон, Авлигатай тэмцэх газраас хянуулах бичгээр зөрчилтэй ирсэн зэрэг 8 албан хаагчын зөрчлийг арилгав.<br>Яамны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, ажлын байрыг батлахдаа Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтад Ахлах нягтлан бодогч гэж ажлын байр байхгүй бөгөөд дээрх зөрчлийг арилгаж, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/28 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж, "Ерөнхий нягтлан бодогч" гэсэн зөрчлийг арилгав.<br>Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдөл өгсөн 3 албан хаагчийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1.1 | Эрх зүйч мэргэжлээр суралцан төгсөх | Эрх зүйчээр төгссөн эсэх | Албан хэрэгцээний хүрээнд эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор Худалдааны үндэсний их сургуулийн Эрх зүйн оройн ангид 2022 оноос эхлэн суралцан, 20204 онд МУИС-ийг Эрх зүйч мэргэжил эзэмшсэн.<br>Одоо 2-р курсийн төгсөх шалгалтуудаа өгч байна.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.31<br>Биелэлт: 100% /хугацаандаа/ |

| | | | |
|---|---|---|---|
| 1.2 | Мэргэшүүлэх багц сургалтад суралцах | Мэргэшүүлэх багц сургалтад суралцан төгссөн эсэх | Удирдлагын академийн "Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт"-д суралцаж байгаад жирэмсэн, хүүхэд асрах чөлөө авч, завсардсан.<br>E721, E723 хичээлүүдийг дахин судлах хүсэлт гаргасны дагуу 2024 оны 12 дугаар сард суралцах хуваарийн дагуу суралцлаа.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.31<br>Биелэлт: 100% /хугацаандаа/ |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ШИНЖЭЭЧ ............................ /Д.МӨНХЦЭЦЭГ/ 2024 оны 12 дугаар сарын 09

# СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ ДАЛАНТАЙН МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Стратеги, бодлого төлөвлөлтийн газар**

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь тайлагнах зорилтын хүрээнд** | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Ерөнхий сайдын 02 дугаар албан даалгаварын хүрээнд салбарын хүний нөөц, цахим, ногоон хөгжлийн стратеги, төлөвлөгөөний төсөл боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулах | 60 | - | 60 | 60 |
| 2 | **Арга хэмжээ 1.2:** Яамны хөдөлмөрийн дотоод журам боловсруулж батлуулах | 60 | - | 60 | 60 |
| 3 | **Арга хэмжээ 1.3:** 2025 оны эвент, арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт боловсруулах | 60 | - | 60 | 60 |
| 4 | **Арга хэмжээ 1.4:** Яамны бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулах | 60 | - | 60 | 60 |
| 5 | **Арга хэмжээ 1.5:** Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын процессын дахин инженерчлэлийн төлөвлөгөө | 60 | - | 60 | 60 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, санал хүргүүлэх | | | | |
| 6 | **Арга хэмжээ 1.6:** Олимпыг наадамд эрх авч оролцсон, амжилт гаргасан тамирчин дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 60 | – | 60 | 60 |
| **Зорилт 2.** "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1:** Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бүтэц, зохион байгуулалтын зураглал, төлөвлөлт, холбогдох баримт бичгийг боловсруулан батлуулах | 60 | – | 60 | 60 |
| 2 | **Арга хэмжээ 2.2:** Хүний нөөцийн аудитын судалгаа, тайлан гаргаж хүргүүлэх | 60 | – | 60 | 61 |
| 3 | **Арга хэмжээ 2.3:** Сайдын бодлогын зөвлөл байгуулах төслийг боловсруулж танилцуулах | 60 | – | 60 | 60 |
| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
| 1 | Яамны засвар, тохижилтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх | 60 | – | 60 | 60 |
| 2 | Яамны хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | 60 | – | 60 | 60 |
| **Дундаж оноо:** | | | | 60 | 61 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | **Арга хэмжээ 1.** Эрх зүйч мэргэжлээр суралцан төгсөх | 60 | 15 | 15 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | **Арга хэмжээ 2.** Мэргэшүүлэх багц сургалтад суралцах | 60 | 15 | 15 |
| **Дундаж оноо:** | | | 15 | 15 |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо:** | | 7 | 7 |

4. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)**

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-8 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 | 8 |
| 3 | Харилцаа | 8 | 8 |
| **Дундаж оноо:** | | | 8 |

5. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 60 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Нэгжийн даргын үнэлгээ*) | 7 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Хамт олны үнэлгээ*) | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*) | |
| **Нийт оноо:** | | 90 / 91 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Стратеги, бодлого төлөвлөлтийн Газрын дарга ........................................ (А.Даваажаргал)
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Салбарын нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт тайлагналт хариуцсан инжээч ........................................ (Д.Мөнхцэцэг)
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

........................ (огноо)

***Үнэлгээг хянасан:*** ***Үнэлгээний багийг төлөөлж, ахлагч***

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ........................................ (Д.Түмэндэмбэрэл)
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

2024.12.13 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

ТЗУТ-ийн ахлах мэргэжилтэн ........................................ (Х.Даваадорж)
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

2024.12.13 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................................ (А.Даваажаргал)
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

........................ (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Соёл, урлаг, аялал жуулчлалын нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн Лувсанзундуй Ариунтунгалаг

2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1 | Салбарын стратеги төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх | Санал боловсруулж хүргүүлэх | - | Санал боловсруулж хүргүүлсэн байна. | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд соёлын салбарын мандатын шинжилгээ, орчны шинжилгээ хийж соёлын салбарын үндсэн 5, дэд 44 чиг үүргийг тодорхойлж НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн зөвлөхүүдэд хүргүүлсэн. | 10-р сар | 100% |
| 2 | Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын биелэлт хангах | Сайдын албан даалгавар гаргах | - | Биелэлтийг ТНБД-ын зөвлөлд хэлэлцүүлсэн байна. | Ерөнхий сайдын 01 дугаар албан даалгаварын биелэлтийг хангаж “Ажил эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” ССАЖЗ-ын сайдын 02 дугаар албан даалгавар гарав. | 10-р сар, 11-р сар 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын биелэлтийн явцыг салбарын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан гаргах | Явцын тайлан хүргүүлэх | - | Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэх | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 01/727 дугаар албан бичгээр ирүүлсэн Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварт тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хэрэгжүүлэх 7 ажлын биелэлтийг харьяалах салбаруудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан гаргаж ТНБД-ын 3/1040 дугаар албан бичиг болон n.lkham@ags.gov.mn цахим хаягаар хариуг хүргүүлсэн. | 11-р сар | 100% |
| 4 | Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлэх | Санал боловсруулж хүргүүлэх | - | Санал боловсруулж ТБҮХ-нд хүргүүлсэн байна. | ЗГҮАХ-ийн 4.3-т заасан чиглэлээр Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар салбарын саналыг боловсруулж тус хорооны ажлын албанд ТНБД-ын 3/1179 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 10-р сар<br>11-р сар | 100% |
| 5 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9-т заасны дагуу холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Хамтарсан ажлын хэсэг байгуулах | | | ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9-т заасан нэмэлт өөрчлөлтийн дагуу албан татварын хөнгөлөлтөд хамрагдах соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын А/76 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгийн 2 удаагийн хурлыг Татварын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан. | 10-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Соёлын хүртээмжийн 2021-2024 оны тоон мэдээлэл гаргах | Тоон мэдээлэл | - | Ажлын албанд хүргүүлсэн байна. | Соёлын салбарын үйлчилгээ, үйл ажиллагааны хүртээмжийн 2021-2024 оны тоон мэдээллийг албан болон албан бус статистикийн 25 үзүүлэлтээр нэгтгэн гаргаж холбогдох дүгнэлт, мэдээллийг сайдын соёл,урлагийн бодлогын зөвлөхөд хүргүүлсэн. | 11-р сар | 100% |
| 7 | Яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлж ажиллах | - | Тайлан мэдээлэл гаргаж дэмжлэг үзүүлсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлд салбарын бодлого, хууль тогтоомжид сүүлийн хоёр жилд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл бэлтгэн яамны дэргэдэх дэд зөвлөлд хүргүүлэв. | 10-р сар, 11-р сар | 100% |
| 8 | "Цайны их зам" дагуух өвийг хамгаалах гурван улсын нэгдсэн хуралд оролцох , санаачилга гаргахад дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг үзүүлж ажиллах | - | Нэгдсэн хуралд оролцож саначлагын төсөл болвсруулсан байна. | БНХАУ-ын Хубэй мужын Ухань хотод хуралдсан Монгол-Орос-Хятад улсын нутаг дахь "Цайны их зам" дагуух өвийг хамгаалах талаар гурван улсын санаачлага гаргах нэгдсэн хуралд оролцож "Цайны их замын соёлын өвийг хамгаалах тухай Уханы санаачилга"-ын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллав. | 12-р сар | 100% |
| 1.2.Соёлын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах | | | | | | | |
| 9 | Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төсөл боловсруулж батлуулах | Журмын төсөл батлагдсан эсэх | - | Журмын төсөл боловсруулсан байна. | Соёлын тухай хуулийн 26.4-т "Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн | 10-р сар, 11-р сар 12-р сар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засгийн газрын гишүүн батална" гэж заасны дагуу салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төслийг боловсруулж 10.14-ны өдрийн ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаар салбарын ТББ-ын судалгааг чиг үүргийн шинжилгээтэй уялдуулан нарийвчлан хийж, журмын төсөлд яамны бүтцийн нэгжүүдээс санал авах ажил зохион байгуулсан. | | |
| 10 | Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох журмын төсөл боловсруулах | Журмын төсөл боловсруулах | "Уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журам" ЗГ-ын 2008 оны 120 дугаар тогтоол | Журмыг шинэчлэх төсөл боловсруулж ТНБД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. | Соёлын тухай хуулийн 32.9-т "Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална" гэж заасны дагуу Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолоор баталсан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох тухай журам, уралдаан наадмын жагсаалтыг өөрчлөх төсөл боловсруулж 10.14-ны өдрийн ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулсан. | 10-р сар, 11-р сар | 100% |
| 1.3. Нэмэлт үүрэг даалгаварын биелэлт | | | | | | | |
| 11 | Хамтарсан засгийн газрын гэрээнд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал | Санал боловсруулж хүргүүлэх | - | Санал боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Хамтарсан засгийн газрын гэрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал боловсруулж | 7-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлэх | | | | сайдын 1/10 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | |
| 12 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал хүргүүлэх | Санал боловсруулж хүргүүлэх | - | Санал боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал боловсруулж сайдын сайдын 1/11 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 7-р сар | 100% |
| 13 | Олимпын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчдад олгох урамшууллын талаар шийдвэрийн төсөл боловсруулах | Шийдвэрийн төсөл боловсруулж хүргүүлэх | - | ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | “Парис 2024” зуны XXXIII олимп, XVII паралимпын наадамд амжилттай оролцсон зарим тамирчин, шүүгч нарыг шагнаж урамшуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг сайдын 1/398 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн хуралдаанаар “Парис 2024” зуны XXXIII олимп, XVII паралимпын наадамд амжилттай оролцсон зарим тамирчдыш шагнаж урамшуулах тухай” 77 дугаар тогтоол гарсан. Мөн өдрийн хуралдаанаар 32 дугаар тэмдэглэлээр “Парис 2024” зуны XXXIII олимп, XVII паралимпын наадамд эрх авсан тамирчин болон шүүгч нарт мөнгөн урамшуулал олгох тухай” тэмдэглэл тус тус гарсан. | 8-р сар, 9-р сар | 100% |
| 14 | Олимпыг наадамд эрх авч оролцсон, амжилт гаргасан | Арга хэмжээ зохион | - | Хүндэтгэлийн арга хэмжээ | “Парис 2024” зуны XXXIII олимп, XVII паралимпын наадамд эрх | 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тамирчин дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах | байгуулах | | зохион байгуулсан байна. | авсан тамирчин болон шүүгч нарт мөнгөн урамшуулал олгох тухай" Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлийн олимп, паралимпын наадамд оролцох эрх авч оролцсон тамирчин, олон улсын шүүгч нийт 48 хүн тус бүрд олгох нэг удаагийн мөнгөн урамшууллыг сайдын А/40 дүгээр тушаалаар олгох шийдвэр гарсан. | | |
| 15 | Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн ахмад тамирчинд олгох урамшууллын талаар шийдвэрийн төсөл боловсруулах | Шийдвэрийн төсөл боловсруулж хүргүүлэх | - | ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Швед Улсын Гётенберг хотод 2024 оны 8 дугаар сард зохион байгуулагдсан хөнгөн атлетикийн мастеруудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хөнгөн атлетикийн ахмад тамирчин, Ц.Раднаа 90-95 насны ангилалд оролцож 6 Алтан медаль хүртсэн амжилтыг урамшуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг сайдын 1/450 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 9-р сар | 100% |
| 16 | ССАЖЗЯ-ны 2024-2025 онд бусад яамдтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах | Төлөвлөгөө боловсруулах | - | Төлөвлөгөөг ТНБД-д хүргүүлсэн байна. | ССАЖЗЯ-ны 2024-2025 онд бусад яамдтай хамтран ажиллах төлөвлөгөөний төсөл боловсруулж ТНБД-д хүргүүлэв./Ч.Цэвэгдорж/ | 9-р сар | 100% |
| 17 | ССАЖЗЯ-ны 2024, 2025 оны эвент арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах | Төлөвлөгөө боловсруулах | - | Төлөвлөгөөг сайдын Ажлын албанд хүргүүлсэн байна. | Сайдын 2024.09-12 дугаар сарын арга хэмжээний төлөвлөгөө, яамны 2025 оны эвент арга хэмжээний төлөвлөгөө төсөл боловсруулж сайдын ажлын | 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албанд хүргүүлэв. | | |
| 18 | Шинэчлэн байгуулагдсан яамны албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлж ажиллах | - | Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажилд дэмжлэг үзүүлсэн байна. | СБТГ, НТХ-ийн нийт 16 Албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулж ТЗУГ-т хүргүүлэв. | 9-р сар | 100% |
| 1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 19 | Яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу ССАЖЗЯ-ТНБД-ын А/65 дугаар тушаалаар байгуулагдсан яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилогдон хорооны 3 удаагийн хуралд ажилласан. | 11-р сар 12-р сар | 100% |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Танхим болон цахимаар сургалтад хамргадана. | | 1-ээс доошгүй сургалтад хамрагдах | Дэлхийн оюуны өмчийн байгууллага /WIPO/-аас зохион байгуулсан “Патентийн хууль тогтоомж ба нийгмийн эрүүл мэнд” цахим сургалтад хамрагдаж оюуны өмч, патентийн эрхийн талаарх олон улсын чиг хандлагыг судалсан. | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Соёл, урлаг, аялал жуулчлалын нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн Лувсанзундуй Ариунтунгалаг/............................................................/

Огноо: ..........................

112

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# СТРАТЕГИ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЛУВСАНЗУНДУЙН АРИУНТУНГАЛАГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Нэгдсэн төлөвлөлтийн хэлтэс**

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд** | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Салбарын стратеги төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | 60 | | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2:** Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын биелэлт хангана. | 60 | | | |
| 3 | **Арга хэмжээ 1.3:** Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын биелэлтийн явцыг салбарын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан гаргана. | 60 | | | |
| 4 | **Арга хэмжээ 1.4:** Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлнэ. | 60 | | | |
| 5 | **Арга хэмжээ 1.5:** ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9-т заасны дагуу холбогдох байгууллагатай хамтран ажиллана. | 60 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | **Арга хэмжээ 1.6:** Соёлын хүртээмжийн 2021-2024 оны тоон мэдээлэл гаргана. | 60 | | | |
| 7 | **Арга хэмжээ 1.7:** Яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 60 | | | |
| 8 | **Арга хэмжээ 1.8:** “Цайны их зам” дагуух өвийг хамгаалах гурван улсын нэгдсэн хуралд оролцож санаачилга гаргахад дэмжлэг үзүүлнэ. | 60 | | | |
| **Зорилт 2. Соёлын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах хүрээнд** | | | | | |
| 9 | **Арга хэмжээ 2.1:** Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төсөл боловсруулж батлуулна. | 42 | | | |
| 10 | **Арга хэмжээ 2.2:** Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох журмын төсөл боловсруулна. | 60 | | | |
| **Зорилт 3. Нэмэлт үүрэг даалгаварын биелэлтийг хангах хрээнд** | | | | | |
| 11 | **Арга хэмжээ 3.1:** Хамтарсан засгийн газрын гэрээнд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал хүргүүлнэ. | 60 | | | |
| 12 | **Арга хэмжээ 3.2:** Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тусгуулах санал хүргүүлнэ. | 60 | | | |
| 13 | **Арга хэмжээ 3.3:** Олимпын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчдад олгох урамшууллын талаар | 60 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн төсөл боловсруулна. | | | | |
| 14 | **Арга хэмжээ 3.4:** Олимпыг наадамд эрх авч оролцсон, амжилт гаргасан тамирчин дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | 60 | | | |
| 15 | **Арга хэмжээ 3.5:** Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн ахмад тамирчинд олгох урамшууллын талаар шийдвэрийн төсөл боловсруулна. | 60 | | | |
| 16 | **Арга хэмжээ 3.6:** ССАЖЗЯ-ны 2024-2025 онд бусад яамдтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулна. | 60 | | | |
| 17 | **Арга хэмжээ 3.7:** ССАЖЗЯ-ны 2024, 2025 оны эвент арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулна. | 60 | | | |
| 18 | **Арга хэмжээ 3.8:** Шинэчлэн байгуулагдсан яамны албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | 60 | | | |
| **Зорилт 4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд** | | | | | |
| 19 | **Арга хэмжээ 4.1:** Яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ажиллана. | 60 | | | |
| **Дундаж оноо:** | | | | 61 | 61 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | **Арга хэмжээ 1.** Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | 100 | 15 | 14 |
| **Дундаж оноо:** | | | **15** | 14 |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | - | - |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2. | - | - |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 3. | - | - |
| **Дундаж оноо:** | | 7 | 7 |

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-8 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 | 8 |
| 3 | Харилцаа | 8 | 8 |
| **Дундаж оноо:** | | | 8 |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 61 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Нэгжийн даргын үнэлгээ)* | 7 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*Хамт олны үнэлгээ*) | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*) | |
| **Нийт оноо:** | | 90/90 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга
(*албан тушаал*)

........................ (*гарын үсэг*)

(А.Даваажаргал)
(*албан хаагчийн нэр*)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Соёл, урлаг, аялал жуулчлалын нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн
*(албан тушаал)*

.......................................... *(гарын үсэг)*

(Л.Ариунтунгалаг)
*(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж, ахлагч***

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
*(албан тушаал)*

.......................................... *(гарын үсэг)*

(Д.Түмэндэмбэрэл)
*(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн
*(албан тушаал)*

.......................................... *(гарын үсэг)*

(Х.Даваадорж)
*(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)*

.......................................... *(гарын үсэг)*

(А.Даваажаргал)
*(албан хаагчийн нэр)*

........................ (огноо)